



УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 21/19

Улаанбаатар хот


Захиргааны зөвлөлийн
журам батлах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, музейн стандартын 8 дугаар зүйлийн 8.1 дүгээр заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Музейн захирлын дэргэдэх захиргааны зөвлөлийн журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ  С. ЦАЦРАЛТ



УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙН ЗАХИРЛЫН ДЭРГЭДЭХ ЗАХИРГААНЫ ЗӨВЛӨЛИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Улаанбаатар хотын музейн Захиргааны зөвлөл /цаашид "Зөвлөл" гэнэ/-ийн чиг үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны нийтлэг зарчим, бүрэн эрх, үйл ажиллагааны хэм хэмжээг тодорхойлж, зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2. Зөвлөл нь музейн захирал бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд холбогдох асуудлаар захиргааны шийдвэр гаргахад зөвлөгөө өгөх, захиргааны шуурхай удирдлагыг хангахад дэмжлэг үзүүлэх хамтын удирдлагын тогтолцоо юм.
- 1.3. Зөвлөл нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй.
- 1.4. Зөвлөл нь Төрийн албаны тухай хууль, Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, бусад хууль тогтоомж болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн

- 2.1. Зөвлөл нь 5 хүний бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөл нь дарга, мэргэжилтнүүдээс бүрдэнэ.
- 2.2. Зөвлөлийн дарга нь музейн захирал байна.

Гурав. Зөвлөлийн хурлын дэг, шийдвэр

- 3.1. Хуралдаанаар хэлэлцэх асуудал бүрт зарцуулах хугацаа, асуулт тавих, санал хэлэх хугацааг хуралдааны дарга тухай бүр тогтооно.
- 3.2. Хэлэлцэх асуудлыг гишүүн эсвэл холбогдох ажилтан биечлэн танилцуулна.
- 3.3. Асуудлыг танилцуулсны дараа гишүүд асуулт тавьж, санал дүгнэлтээ хэлнэ. Гишүүн хуралдааны даргаас зөвшөөрөл авч тогтоосон хугацаанд багтааж санал дүгнэлтээ хэлнэ.
- 3.4. Зөвлөлийн шийдвэрийг олонхийн саналаар батлах бөгөөд шаардлагатай бол захирал тухайн асуудлаар тушаал гаргана.
- 3.5. Бодит байдалтай танилцаж, мэдээлэх зорилгоор холбогдох албан тушаалтнуудыг байлцуулан хуралдааныг өргөтгөсөн бүрэлдэхүүнтэй хийж болно.
- 3.6. Зөвлөлийн хуралд оролцогсод нь шаардлагатай бол хэлэлцсэн асуудлыг нууцална.
- 3.7. Зөвлөл жилд 2 ба түүнээс дээш удаа хуралдах ба хурлыг бүх гишүүдийн гуравны хоёроос дээш ирцтэй хийнэ.

Гурав. Зөвлөлийн үйл ажиллагаа

- 3.1. Зөвлөл нь музейн үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлд хяналт тавьж, тулгамдсан асуудлаар хуралдаж хэлэлцэнэ.
- 3.2. Зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
 - 3.2.1. Музейн үйл ажиллагааг жигд тасралтгүй, үр дүнтэй явуулахад хяналт тавьж чиглүүлэх
 - 3.2.2. Музейн үйл ажиллагааны тулгамдсан асуудлаар санал дүгнэлт гарах
- 3.3. Зөвлөлийн хурлыг гишүүдийн 60-аас дээш хувийн ирцтэйгээр явуулна.

3.4. Шаардлагатай тохиолдолд хурлаар хэлэлцэх, шийдвэрлэх асуудлыг гишүүдэд бичгээр тарааж саналыг авч болох бөгөөд дараагийн хуралд гүйцэтгэлийг хэлэлцэж болно.

3.5. Зөвлөл нь дараах чиглэлийн асуудлыг хэлэлцэж шийднэ.

3.5.1. Музейн үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ерөнхий бодлого, чиглэл, өдөр тутмын үйл ажиллагаа хэрхэн биелж байгаа талаар

3.5.2. Музейн стандарт, төлөвлөгөө, хөтөлбөрийн гүйцэтгэлийн явц

3.5.3. Мэргэжилтэн, албан хаагчид музейн үндсэн үйл ажиллагааг тасралтгүй хөтлөн явуулах

3.5.4. Мэргэжилтэн, албан хаагчдыг шагнал урамшуулалд дэвшүүлэх асуудлыг хэлэлцэх

3.5.5. Алдаа дутагдал гаргасан ажилтны асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх асуудлыг төлөвлөх

3.5.6. Музейн гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэгдсэн санал санаачлага, үзэл баримтлалуудыг дэмжих

3.5.7. Мэргэжилтэн, албан хаагчдын жилийн ажлын төлөвлөгөө, тайланг хэлэлцэх

3.5.8. Музейн жилийн ажлын төлөвлөгөө тайланг хэлэлцэх

Дөрөв. Зөвлөлийн гишүүдийн эрх

4.1. Асуудал хэлэлцэхэд санал дүгнэлтээ оруулах

4.2. Зөвлөлийн хурлаар хэлэлцэж байгаа аливаа асуудлаар шийдвэр гаргах үед дэмжих, татгалзах, түдгэлзэх

4.3. Зөвлөлөөр хэлэлцэж байгаа асуудлыг хойшлуулах, дахин хянан үзэх санал гаргах

4.4. Өөрийн саналаар зайлшгүй шаардлагатай асуудлыг хурлаар хэлэлцүүлэх

Тав. Зөвлөлийн гишүүдийн үүрэг

5.1. Музейн үндсэн үйл ажиллагааны явцад байнгын хяналт тавьж, удирдах, чиглүүлэх

5.2. Зөвлөлийн хуралд хүндэтгэх шалтгаангүй бол заавал оролцох

5.3. Зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх

Зургаа. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах ба хүчин төгөлдөр болох

6.1. Зөвлөлийн журамд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг музейн захирал болон Зөвлөлийн гишүүд гаргаж болно.

6.2. Нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг музейн захирал болон зөвлөлийн өргөтгөсөн хурлаар хэлэлцэж захирал батлах бөгөөд баталсан тухай шийдвэр гаргаснаар хүчин төгөлдөр болно.